

ШҮҮМЖ, НОМ ЗҮЙ

М. Г. НОСОВ. «ЯПОНО-КИТАЙСКИЕ ОТНОШЕНИЯ» (1949-1975)**Изд-во «Наука» М., 1978. 216 с.**

Япон-хятадын улс төр, эдийн засгийн харилцааны судалгаанд зориулсан энэ номдоо зохиогч нэг талаар Японы гадаад бодлогод Хятадын эзэлж байгаа байр суурь, нөгөө талаар Японы гадаад бодлогын үлэмж чухал чиглэлүүдтэй нягт холбоотой япон-хятадын харилцааг судлахыг гол зорилго болгожээ. Уул номоо дайны дараахи япон-хятадын харилцааны хөгжлийг бүхэлд нь хамарсан 5 хэсэгт хувааж бичсэн байна.

Нэгдүгээр хэсэгт нь БНХАУ тунхагласан 1949 оноос хятад-японы хоорондын харилцааг бүрэн зогсооход хүргэсэн 1958 оны «Нагасакийн хэрэг явдал» хүртэл үеийг авч үзжээ. Энэ үед худалдаа эдийн засгийн холбоог өргөтгөх замаар Японтой дипломат харилцаа тогтоох суурь тавих гэсэн Хятадын оролдлогыг америкийн талыг баримталсан японы эрх баригч бүлгийнхэн хавчин боогдуулж байв. Үүнтэй холбогдуулж английн «Таймс» сонин бичихдээ: «Японы үйлдвэрийн эзэд хятадын хориотой зах зээл рүү гунигтай ширтэж байгаад гайхах зүйл үгүй. Учир нь Япон улс Хятадтай худалдаа хийхийг хориглосон америкийн зааврыг чанд сахиж байгаа юм» гэжээ. Тэгэхдээ Японы засгийн газар «эдийн засгаас улс төрийг тусгаарлах» зарчим дээр Хятадтай засгийн газрын биш, хувийн шугамаар худалдааны харилцаа хөгжүүлэх нь ашигтай гэдгийг харгалзаж үзсэнийг тэмдэглэвэл зохино.

Хятадын удирдлага Японы талын худалдаагаа хөгжүүлэх гэсэн сонирхлыг хятад-японы харилцааг хэвийн болгох асуудалд шүүрэн авч ашигласан юм. Ийм аргад шилжсэн нь Хятадын гадаад бодлогын адал балмад хандлагатай шууд холбоотой.

Дараахи үе нь 1958 оны «Нагасакийн хэрэг явдлаас» 1966 оны «соёлын хувьсгал» эхлэх хүртлэх хэрэг явдлыг хамаарна. Зохиогч энэ үеийг Токио, Бээжингийн холбоо бүрэн зогсонги байдлаас аажмаар сэргэж, улмаар япон-хятадын албан ёсны биш эдийн засаг, улс төрийн харилцаа түргэн хөгжиж эхэлсэн шилжилтийн үе гэж тодорхойлжээ.

Үүнтэй холбогдуулан зохиогч Тайваний талаархи японы бодлого идэвхжсэн гол шалтгааныг авч үзсэн байна. Японы засгийн газар Зүүн Өмнөд Азийн орнуудад эдийн засгийн өнгөлзлөг явуулахад Чан Кай-шийн Тайвань түшиг болно гэж үзэж байсанд хэргийн учир оршино.

Энэ үед Хятадтай худалдаа өргөтгөхийг сонирхогчдоос хоёр улсын хоорондох эдийн засгийн холбоог сэргээх гэсэн оролдлогыг тодорхой баримтаар харуулжээ. Эрх барих намын зарим төлөөлөгчид япон-хятадын худалдааг сэргээх талаар идэвхижсэнийг зохиогч хэд хэдэн хүчин зүйлээр тодорхойлжээ.

60-аад оны дундаас хятадын худалдааны байгууллагууд, японы «нөхөрсөг» пүүсүүдийн хооронд эдийн засгийн холбоо аажмаар сэргэж эхлэв. Ийм хэлбэрийн эдийн засгийн холбоо нь япон-хятадын худалдааны нэг чухал зам болсныг зохиогч онцлон тэмдэглэжээ.

Нөгөө талаас Хятадтай харилцаа хөгжүүлэх японы сонирхлыг улам их татахад тус дөхөм үзүүлсэн нэг чухал хүчин зүйл бол Японы гадаад худалдааны тэнцүүрийн алдагдал гэнэт нэмэгдсэнтэй холбоотой болно.

Жишээлбэл: Ерөнхий сайд Икэда, япон-хятадын худалдааны талаархи бодлогоо илэрхийлэн хэлэхдээ: «Худалдаа бол бидний амьдралын гол арга, иймд манай бодлого худалдааг өргөтгөхөд оршино, харин бид коммунизмыг худалдан аваагүй шүү дээ» (64. т) гэжээ.

1965 оноос Хятадын хамгийн том худалдааны хамсаатан нь Япон болов. Эдийн засгийн холбоо хөгжүүлэхэд чиглэсэн хятадын сонирхлыг ашиглан, японы монополиуд өөртөө ашигтай худалдааны нөхцөлийг Бээжинд тулган хүлээлгэж чадав. БНХАУ «эдийн засгаас улс төрийг тусгаарлах» японы чиг шугамыг элдвээр буруушааж байлаа ч, хэрэг дээрээ уул шугамыг аргагүй хүлээн зөвшөөрсөн нь япон-хятадын худалдаа ийнхүү түргэн хөгжсөнөөс харагдаж байна.

Зохиогч япон-хятадын харилцааны хөгжлийн II үеийг тодорхойлон бичихдээ, «хувийн худалдаанаас улс хоорондын эдийн засгийн хэлхээ холбоонд шилжсэнээр Хятад, Японы аль аль нь зохих ашиг олох болов» гэжээ.

Дараахи III үед (1966 оны наймдугаар сарын «соёлын хувьсгалаас» 1971 оны гуравдугаар сар хүртлэх) зохиогчийн цохон зааснаар «соёлын хувьсгалын» уршгаар Хятадын гадаад бодлогын идэвх зарим талаар суларч, харин БНХАУ-ыг хүлээн зөвшөөрүүлэх асуудлаар Бээжин Японы засгийн газарт шахалт үзүүлэх оролдлого эхэлж байв.

Энэ үед Японы засгийн газар «эдийн засгаас улс төрийг тусгаарлах», «Тайваньтай харилцаагаа хадгалан, Бээжинтэй худалдаагаа үргэлжлүүлэх» зарчмыг баримталсаар байв.

«Соёлын хувьсгалын» үед хятадын удирдлагын гадаад бодлогод зөвлөлтийн эсрэг үзэл нэн гаарч Хятад маоист чиг бодлогоо японы ардчилсан хөдөлгөөнд тулган хүлээлгэхийг шийдсэнийг уг номд иш баримттай дурджээ.

Зохиогч 1971 оны 3-р сараас 1972 оны 9-р сар хүртэлх IV дэх үе, өөрөөр хэлбэл, дипломат харилцаа тогтсон үед болсон гол үйл явдлыг номондоо тодорхой тусгасан байна.

1972 оны 9-р сарын 25-нд «Токио, Бээжингийн хооронд дипломат харилцаа тогтоосныг» тунхаглан зарласан БНХАУ, Япон улсын засгийн газрын мэдэгдэлд гарын үсэг зурсан билээ.

Хятадын удирдлага японы эрх барих бүлгийн явуулж байгаа милитарист бодлогыг буруушаахаа больж, чухамдаа япон-америкийн цэргийн холбоог зөвшөөрсөн нь японы гадаад бодлогын гол шугамын иэгийг хүлээн зөвшөөрсөн хэрэг юм. Харин Японыг зөвлөлтийн эсрэг үзэлд татан оруулах гэсэн Бээжингийн оролдлого нь (жанжлалын тухай, өөрөөр хэлбэл хоёр их гүрэн АНУ, ЗХУ-ын жанжлал, юуны өмнө ЗХУ-ын жанжлал гэсэн зүйлтэй) энх тайван, найрамдлын гэрээ байгуулах тухай хятадын саналд Японы засгийн газрыг болгоомжтой хандахад хүргэсэн байна.

Хятадтай хэлхээ холбоогоо хөгжүүлснээр японы эрх барих бүлэг Зүүн Өмнөд Азийн орнуудад явуулж байгаа өөрийн эдийн засгийн өнгөлзлөгийг найдвартай хамгаалж чадна гэж үзэж байв. «Хятад нь японы зах зээлийг түшихэд хүрч Японы талаар өнгөн дээрээ буулт хийхгүй, хатуу бодлого баримталж байгаа мэт боловч, чухамдаа хоёр улсын хоорондох худалдаа хөгжүүлэхийг гол санаачлагч нь Хятад юм» гэж зохиогч дүгнэсэн байна.

Номын төгсгөлд зохиогч япон-хятадын харилцааны ирээдүйг ямар ч хир буртаггүй гэж үзэж болохгүй, хоёр орны хооронд ноцтой зөрчил байгаа, мөн япон хятадын харилцааны үндсэнд тэдгээр орны ард түмний амин ашиг биш, харин түр зуурын сонирхол оршиж байгаагаар тайлбарлажээ.

Япон, Хятадын эдийн засаг, улс төрийн бодлогын гол асуудлаар хийсэн Зөвлөлтийн эрдэмтдийн судалгааны үндэслэлд тулгуурлан зохиогч өөрийн бүтээлдээ бодитой баримт сэлтийн үндсэн дээр сүүлийн үеийн Япон-хятадын харилцааны шинж, мөн чанарын талаар хэд хэдэн шинэ дүгнэлт хийсэн байна.

Зохиогч ЗХУ-ын тунхагласан энх тайвнаар зэрэгцэн орших сайн хөршийн зарчим нь улам их нөлөө үзүүлэн гадаад улс төрийн бодлогын асуудалд бодитой хандах хандлага л давуу болохоо харуулж байна гэж зөв зүйтэй дүгнэсэн байна.

Ерөнхийдөө, Япон-Хятадын одоо үеийн эдийн засаг, улс төрийн асуудалд зориулсан М. Г. Носовын судалгааны энэ зохиол мэргэжлийн хүмүүс болон өргөн олон уншигчдад дээрх хоёр орны харилцааны талаар цогц ойлголт өгөх чамбай бүтээл болсон нь дамжиггүй.

О. Оюунгэрэл